

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/28/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Tsevelmaab@audit.gov.mn">Tsevelmaab@audit.gov.mn</a>
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.22

№

06

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилтанд цалин илүү бодож олгосон, шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлагыг заал түрээсийн орлогоос төлсөн, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр төсөв зарцуулсан, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/22 дугаар захирамж, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020845

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>98,217,416.00</b>	<b>90,881,016.00</b>
33	<b>АВЛАГА</b>	59,719,600.00	41,420,000.00
335	<b>Бусад авлага</b>	59,719,600.00	41,420,000.00
3351	Байгууллагаас авах авлага	55,980,000.00	38,280,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,739,600.00	3,140,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38,497,816.00	49,461,016.00
351	<b>Түүхий эд материал</b>	19,349,100.00	23,875,600.00
35110	Тусгай зориулалттай материал	19,349,100.00	23,687,100.00
35130	Эм боох материал	-	188,500.00
354	<b>Хангамжийн материал</b>	19,148,716.00	25,585,416.00
35410	Бичиг хэргийн материал	914,400.00	1,132,400.00
35420	Аж ахуйн материал	3,715,536.00	5,215,236.00
35430	Сэлбэг хэрэгсэл	390,000.00	1,854,000.00
35450	Барилгын засварын материал	1,947,900.00	5,202,900.00
35460	Хүнсний материал	29,230.00	29,230.00
35470	Бусад хангамжийн материал	12,151,650.00	12,151,650.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,326,264,022.24</b>	<b>1,954,531,519.08</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,326,264,022.24	1,954,531,519.08
392	<b>Биет хөрөнгө</b>	6,176,004,022.24	1,802,771,519.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,928,770,169.64	1,830,757,171.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(155,352,139.44)	(203,828,141.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,100,000.00	17,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,250,000.00)	(4,320,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	322,757,092.01	141,476,920.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,117,351.08)	(78,656,732.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,531,840.99	21,926,140.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,905,849.25)	(15,173,743.67)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,200,000.00	20,200,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	171,160,968.00	169,860,968.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(91,930,708.63)	(96,791,062.96)
39217	Ном	40,000.00	40,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	150,260,000.00	151,760,000.00
39301	Програм хангамж	585,000.00	2,085,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(585,000.00)	(585,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	150,260,000.00	150,260,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,424,481,438.24</b>	<b>2,045,412,535.08</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,424,481,438.24</b>	<b>2,045,412,535.08</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,424,481,438.24	2,045,412,535.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	810,697,946.00	810,697,946.00
51101	Өмч: - төрийн	810,697,946.00	810,697,946.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,092,447,521.91	(286,621,381.25)
51210	Өмнөх үеийн үр дүн	(188,527,032.06)	4,092,447,521.91
51220	Тайлант үеийн үр дүн	4,280,974,553.97	(4,379,068,903.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,521,335,970.33	1,521,335,970.33
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,424,481,438.24</b>	<b>2,045,412,535.08</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,155,654,030.60</b>	<b>669,285,120.82</b>

**Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,372,894,230.60</b>	<b>24,594,520.82</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,372,894,230.60	24,594,520.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,372,894,230.60	24,594,520.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,372,894,230.60	6,604,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,372,894,230.60	17,990,520.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>782,759,800.00</b>	<b>644,690,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	758,961,800.00	249,702,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		249,702,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,798,000.00	35,193,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,864,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,120,000.00	9,274,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,678,000.00	16,055,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	758,961,800.00	359,795,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	758,961,800.00	359,795,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>874,679,476.63</b>	<b>830,360,127.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>874,679,476.63</b>	<b>830,360,127.77</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	782,494,592.57	822,124,811.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224,751,796.29	189,095,937.65
210101	Үндсэн цалин	172,334,299.98	189,095,937.65
210102	Нэмэгдэл	11,748,558.70	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,565,000.00	
210104	Урамшуулал	14,103,937.61	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,665,532.04	26,386,770.92
210201	Тэтгэврийн даатгал	20,451,352.99	18,605,276.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,067,675.83	2,038,381.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,770,116.63	1,630,705.36
210204	Ажилгүйдлийн даатгал	818,762.42	349,234.39
210205	Эрүүл мэндийн даатгал	3,557,624.17	3,763,172.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	297,751,622.73	339,912,888.95
210301	Гэрэл, цахилгаан	1,996,955.61	1,980,021.45
210302	Түлш, халаалт	293,364,157.12	335,452,441.50
210303	Цэвэр, бохир ус	2,390,510.00	2,480,426.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,735,270.88	9,349,135.80
210401	Бичиг хэрэг	1,219,520.00	607,050.00
210402	Тээвэр, шатахуун	2,907,900.00	3,218,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,750.88	1,346,545.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	982,000.00	394,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,128,100.00	3,583,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		199,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	72,573,000.00	28,549,950.00

**Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	72,573,000.00	28,549,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	788,000.00	399,000.00
210702	Дотоод албан томилолт	788,000.00	399,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		1,449,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,897,040.00	1,449,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	555,800.00	
210803	Даатгалын үйлчилгээ	226,820.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,684.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	470,000.00	
210807	Газрын төлбөр	109,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	144,625,026.63	226,981,877.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,715,450.00	32,584,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	531,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,378,576.63	194,397,427.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	92,184,884.06	8,235,316.68
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,750,000.00	2,690,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,750,000.00	2,690,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		5,137,855.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,803,955.63
213304	Хөрөнгийн		1,333,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	85,434,884.06	407,461.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,434,884.06	407,461.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,280,974,553.97</b>	<b>- 161,075,006.95</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		4,217,993,896.21
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		4,217,993,896.21
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		<b>- 4,217,993,896.21</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,280,974,553.97</b>	<b>-4,379,068,903.16</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	810,697,946.00	1,521,335,970.33	4,092,447,521.91	6,424,481,438.24
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,697,946.00	1,521,335,970.33	4,092,447,521.91	6,424,481,438.24
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,697,946.00	1,521,335,970.33	4,092,447,521.91	6,424,481,438.24
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	810,697,946.00	1,521,335,970.33	4,092,447,521.91	6,424,481,438.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00

**Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>810,697,946.00</b>	<b>1,521,335,970.33</b>	<b>4,092,447,521.91</b>	<b>6,424,481,438.24</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,379,068,903.16	-4,379,068,903.16
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>810,697,946.00</b>	<b>1,521,335,970.33</b>	<b>-286,621,381.25</b>	<b>2,045,412,535.08</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>782,759,800.00</u></b>	<b><u>651,694,600.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>7,004,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		7,004,000.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		7,004,000.00
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		<b>7,004,000.0</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>782,759,800.00</b>	<b>644,690,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		<b>249,702,300.00</b>
<b>131001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		249,702,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>35,193,000.00</b>
<b>131103</b>	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,864,000.0
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,274,000.0
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		16,055,000.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>758,961,800.00</b>	<b>359,795,300.00</b>
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	758,961,800.00	<b>359,795,300.0</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>778,809,800.00</u></b>	<b><u>641,906,300.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>778,809,800.00</b>	<b>641,906,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>686,624,915.94</b>	<b>633,670,983.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>224,751,796.29</b>	<b>190,027,164.55</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	172,334,299.98	182,458,073.55
<b>210102</b>	Нэмэгдэл	11,748,558.70	7,569,091.00
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	26,565,000.00	
<b>210104</b>	Урамшуулал	14,103,937.61	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,665,532.04</b>	<b>24,217,044.02</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	20,451,352.99	17,143,252.70
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	1,067,675.83	1,891,329.35
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	1,770,116.63	1,512,882.83
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	818,762.42	333,543.48
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	3,557,624.17	3,336,035.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>297,751,622.73</b>	<b>339,912,888.95</b>
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	1,996,955.61	1,980,021.45
<b>210302</b>	Түлш, халаалт	293,364,157.12	335,452,441.50
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	2,390,510.00	2,480,426.00

**Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,437,770.88</b>	<b>13,061,935.80</b>
210401	Бичиг хэрэг	2,061,520.00	673,050.00
210402	Тээвэр, шатахуун	2,907,900.00	2,667,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,750.88	1,346,545.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	982,000.00	582,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,988,600.00	7,792,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,160,000.00</b>	
210503	Нормын хувцас, зөөлөн адлэл	5,160,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>102,706,900.00</b>	<b>25,268,950.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,906,000.00	
210604	Урсгал засвар	80,800,900.00	25,268,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>788,000.00</b>	<b>399,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	788,000.00	399,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,604,344.00</b>	<b>3,607,250.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,897,040.00	3,607,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	555,800.00	
210803	Даатгалын үйлчилгээ	226,820.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,684.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	470,000.00	
210807	Газрын төлбөр	109,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,758,950.00</b>	<b>37,176,750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,028,950.00	37,176,750.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	730,000.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>92,184,884.06</b>	<b>8,235,316.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,750,000.00</b>	<b>2,690,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,750,000.00	2,690,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>5,137,855.63</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,803,955.63
213304	Хөрөнгийн		1,333,900.0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>85,434,884.06</b>	<b>407,461.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,434,884.06	407,461.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,950,000.00</u></b>	<b><u>9,788,300.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,950,000.00</b>	<b>9,788,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,950,000.00</b>	<b>9,788,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,950,000.00</b>	<b>9,788,300.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,950,000.00	9,788,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(3,950,000.00)</u></b>	<b><u>- 9,788,300.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>616,497,600.0</b>	<b>612,290,183.32</b>	<b>(4,000.00)</b>	<b>100%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>616,497,600.0</b>	<b>612,290,183.32</b>	<b>(4,000.00)</b>	<b>100%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>613,804,200.0</b>	<b>609,600,183.32</b>	<b>4,204,016.68</b>	<b>99%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>190,167,900.0</b>	<b>190,027,164.55</b>	<b>140,735.45</b>	<b>100%</b>
Үндсэн цалин	190,167,900.0	182,458,073.55	7,709,826.45	96%
Нэмэгдэл	-	7,569,091.00	(7,569,091.00)	
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,672,700.0</b>	<b>24,217,044.02</b>	<b>1,455,655.98</b>	<b>94%</b>
Тэтгэврийн даатгал	18,065,900.0	17,143,252.70	922,647.30	95%
Тэтгэмжийн даатгал	1,901,700.0	1,891,329.35	10,370.65	99%
ҮОМШӨ-ний даатгал	1,521,400.0	1,512,882.83	8,517.17	99%
Ажилгүйдлийн даатгал	380,400.0	333,543.48	46,856.52	88%
Эрүүл мэндийн даатгал	3,803,300.0	3,336,035.66	467,264.34	88%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>340,295,300.0</b>	<b>339,912,888.95</b>	<b>382,411.05</b>	<b>100%</b>
Гэрэл, цахилгаан	1,971,200.0	1,980,021.45	(8,821.45)	100%
Түлш, халаалт	335,524,100.0	335,452,441.50	71,658.50	100%
Цэвэр, бохир ус	2,800,000.0	2,480,426.00	319,574.00	89%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,713,100.0</b>	<b>7,191,135.80</b>	<b>521,964.20</b>	<b>93%</b>
Бичиг хэрэг	725,000.0	673,050.00	51,950.00	93%
Тээвэр, шатахуун	2,667,500.0	2,667,140.00	360.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,640,000.0	1,346,545.80	293,454.20	82%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	758,400.0	582,500.00	175,900.00	77%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,922,200.0	1,921,900.00	300.00	100%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,504,200.0</b>	<b>21,268,950.00</b>	<b>235,250.00</b>	<b>99%</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.0	1,794,000.00	6,000.00	100%
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.0	-	204,200.00	0%
Урсгал засвар	19,500,000.0	19,474,950.00	25,050.00	100%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>932,800.0</b>	<b>399,000.00</b>	<b>533,800.00</b>	<b>43%</b>
Дотоод албан томилолт	932,800.0	399,000.00	533,800.00	43%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,111,100.0</b>	<b>5,107,250.00</b>	<b>3,850.00</b>	<b>100%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,111,100.0	5,107,250.00	3,850.00	100%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,407,100.0</b>	<b>21,476,750.00</b>	<b>930,350.00</b>	<b>96%</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	22,407,100.0	21,476,750.00	930,350.00	96%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,693,400.00</b>	<b>2,690,000.00</b>	<b>(4,208,016.68)</b>	<b>256%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,693,400.0</b>	<b>2,690,000.00</b>	<b>3,400.00</b>	<b>100%</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,693,400.0	2,690,000.00	3,400.00	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>616,497,600.0</b>	<b>612,290,183.32</b>	<b>(4,000.00)</b>	<b>100%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>249,702,300.0</b>	<b>245,898,344.37</b>	<b>-</b>	<b>100%</b>
Улсын төсвөөс санхүүжих	249,702,300.0	245,898,344.37	-	100%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>359,795,300.0</b>	<b>359,387,838.95</b>	<b>-</b>	<b>100%</b>
Орон нутгийн төсвөөс	359,795,300.0	359,387,838.95	-	100%

<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,000,000.0</b>	<b>7,004,000.00</b>	<b>(4,000.00)</b>	<b>100%</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.0	7,004,000.00	(4,000.00)	100%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-			
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-			
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>				
Удирдах ажилтан	1	1	0	100%
Гүйцэтгэх ажилтан	10	10	0	100%
Үйлчлэх ажилтан	7	7	0	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>35,193,000.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	35,193,000.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	33,859,100.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	5,870,800.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,870,800.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	12,288,300.00
Багаж, техник, хэрэгсэл		2,100,000.00
Тавилга		4,394,300.00
Урсгал засвар		5,794,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	15,700,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		15,700,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	1,333,900.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,333,900.00
Хөрөнгийн		1,333,900.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>35,193,000.0</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	35,193,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,864,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,274,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,055,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газар нь орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн чиг хандлагад нийцүүлж нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдыг улс, тивийн хэмжээнд өрсөлдөх чадвар, амжилтыг ахиулж залгамж халааг бэлтгэн хөгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 780.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.5 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68 хувиар буюу 4,379.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 41.4 сая төгрөг болж буурсан нь 21.6 сая төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 49.5 сая төгрөг болж 10.9 сая төгрөгөөр өссөн нь барилгын засварын материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 38.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 27.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,353.9 сая төгрөг болж 4,371.7 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 9.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, өмнөх оны авлага 12.9 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, 19.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” ААТҮГ-т 4,300.0 сая төгрөгийн хөрөнгийг, аймгийн Засаг даргын тамгын газарт 38.1 сая төгрөгийн автомашиныг шилжүүлж, 27.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 2,353.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,045.4 сая төгрөг болж 4,379,1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 87 хувиар

буюу 4,486.4 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -286.6 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 935.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 318.9 сая төгрөгөөр бууруулж, 616.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 616.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 249.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 245.9 сая төгрөгийг зарцуулж 3.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс 359.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 359.4 сая төгрөгийг зарцуулж 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 612.3 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.4 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.5 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 0.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 35.2 сая төгрөгийн орлого хүлээн авсан буюу Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.8 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 9.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 16.1 сая төгрөгийн орлогыг тайлагнаж, 1.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг хангамж, бараа материал, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 4, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 452.5 сая төгрөгийн орлого, зарлагын 34 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцсэн, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 99.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 61.5 сая төгрөгийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, бусад шийдвэрийг биелүүлэхээр хууль хяналтын байгууллагад хандсан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, жилийн эцсийн хөрөнгийн тооллого, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 506.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 177.5 сая төгрөгийн алдааг залруулж, 3.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 325.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Авлагыг 3.5 сая төгрөгөөр илүү, дутуу, үндсэн хөрөнгийн тодруулга тайланг 2.9 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланг 3.3 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 19.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн 148.5 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Ажилтанд 3.0 сая төгрөгийн цалин илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/22 дугаар захирамжтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 0.4 сая төгрөгийн авлагыг заал түрээсийн орлогоос төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 8.5 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 5.9 сая төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг

төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроосон мэдээлэл 4, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 452.5 сая төгрөгийн орлого, зарлагын 34 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"-ыг зөрчсөн, АДБОУС 1250 заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас 308.0 сая төгрөгөөр зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 2.1 сая төгрөгийн дутуу, 1.1 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

##### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Ажилтнуудад тавьж олгож зарцуулагдсан бараа материалыг данснаас хасаагүй, бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 12 Бараа материал, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөн ажиллах  
Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
/сая төгрөгөөр/											

Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Биеийн тамир, спортын газар	11	506.6	2	177.5	2	3.4	6	325.7	1	0
---	-----------------------------	----	-------	---	-------	---	-----	---	-------	---	---